

МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТАД ХИЙСЭН НЭГЭН СУДАЛГАА, ҮР ДҮН

Д.Цэдэвсүрэн¹, Б.Норжинбуу²

¹Мэдээлэл зүйн тэнхим, Математик байгалийн ухааны сургууль, МУБИС

²Мэдээлэл зүйн тэнхим, Математик байгалийн ухааны сургууль, МУБИС

¹tsedevsuren@msue.edu.mn, ²norjinbuu@msue.edu.mn

Хураангуй - Энэхүү өгүүлэлд мэдээлэл зүйн боловсролын стандартыг практикт хэрэгжүүлэх үүрэг бүхий мэдээлэл зүйн хөтөлбөрийн өргөсөл гүнзгийрлийг 6-12 дугаар ангийн хөтөлбөрийн жишээн дээр Портерийн загвараар шинжлэн судалж үр дүнг авч үзлээ. Манай улсын Мэдээлэл зүйн боловсролын стандарт (Бага дунд боловсрол. Мэдээлэл зүйн боловсрол, MNS 5420-7:20048, 2005) болон мэдээлэл зүйн сургалтын хөтөлбөр (Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн X-XII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж, 2012) нь агуулга, зорилгын хувьд нилээд ялгаатай боловсруулагдсан байдгаас уг хичээлийн сурах бичиг, багшийн ном, дидактик материал боловсруулах ажилд болон түүнийг практикт хэрэгжүүлэх багш нарт багагүй хүндрэл учруулдаг. Тиймээс мэдээлэл зүйн хөтөлбөрийн агуулгын өргөсөл, гүнзгийрэл ямар байгаа, энэ нь ерөнхий боловсролын түвшинд сурагчдад мэдээлэл холбоо харилцааны технологийн суурь мэдлэг, хэрэглээний чадвар олж авах боломжтойгоор тодорхойлогдсон эсэхийг үнэлэх, үр дүнг мэдээлэл зүйн боловсролын шинэчлэлийн хүрээнд авч үзэхэд уг судалгааны ажлын практик ач холбогдол оршиж байгаа юм.

Түлхүүр үр: Мэдээлэл зүйн боловсрол, мэдээлэл холбоо харилцааны технологи, мэдээлэл зүйн боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичиг

I. МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН ХӨТӨЛБӨР БА ХЭРЭГЛЭСЭН СУДАЛГААНЫ АРГА

A. Баримт бичгийн судалгаа ба Портерийн арга

Портерийн аргыг стандартад өөрийн үнэлгээ хийх, стандарт нь бодит хичээлийн үйл ажиллагаа, багшийн хичээлийн төлөвлөлтийн баримт бичигт хэрхэн тусгалаа олж байгааг илрүүлэх зорилгоор хэрэглэнэ¹. Тодруулбал, Портерийн судалгааны аргыг сургалтын агуулга нь стандарт, хөтөлбөрөөр хүлээгдэж буй үр дүндээ хэрхэн тохирч нийцэж байна вэ гэдгийг тодорхойлоход ашиглаж болно. Мөн сургалтын хөтөлбөр, сургалтын практик үйл ажиллагаа болон сургалтын бусад удирдамж материалын агуулгыг дангаар нь тодорхойлох боломжийг олгох төдийгүй агуулгыг хэмжих шалгуур болох агуулгын өргөсөлт, гүнзгийрэлтийн тодорхой шатуудыг дүрслэн харуулж чаддаг байна.² Энэ аргад хэрэглэж байгаа шалгуурууд нь сургалтын практик үйл ажиллагаа, сургалтын материал хоорондын тохирцыг хэмжих боломжийг

олгодог. Тохирцыг хэмжихдээ эхлээд стандарт, хөтөлбөрөөс эхлэх ба дараа нь үнэлгээ болон сурах бичиг нь тухайн хөтөлбөртэй хэрхэн нийцэж байгааг хэмждэг.

Мэдээлэл зүйн боловсролын хөтөлбөрийн анги бүрээр тодорхойлсон мэдлэг, чадварын тодорхойлолтын тохирцыг шалгах матрицыг гаргаж, Портерийн загвараар агуулгын өргөсөл, гүнзгийрлийг судалж үр дүнг тооцож үзэв. Ингэхдээ агуулгын өргөсөлтөд Мэдээлэл зүйн хөтөлбөрийн агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийг авч, агуулгын гүнзгийрлийг хэмжих шалгуур болгон Портерийн загварын шалгуурыг ашиглав. Портерийн арга нь агуулгын гүнзгийрлийг тодорхойлох шалгуурыг танин мэдэхүйн таван түвшинд хуваан тодорхойлдог. Судалгаанд ашигласан жишээг 1 дүгээр хүснэгтэд үзүүлээ.

ХҮСНЭГТ 1. ПОРТЕРИЙН ЗАГВАРЫН ТАНИН МЭДЭХҮЙН ТҮВШИН, ТЭДГЭЭРИЙН ШАЛГУУР

A	B	C	D	E
Сэргэн санах (Memorize)	Үйлдэл гүйцэтгэх (Perform procedures)	Ухаарч ойлгох (Communicate understanding)	Асуудал шийдвэрлэх (Solve nonroutine problems)	Ерөнхий лөх, нотлох (Conjecture/generalize/prove)
Таних	Тооцоолох	Ухагдахууныг ухаарч ойлгох	Шинэ асуудлыг шийдвэрлэх	Батлах
Ялгах	Ажиглах	Ухагдахууныг загварчлах, ойлгоход тавилуудыг хэрэглэх	Нийгмийн бусад асуудлыг шийдэхэд тухайн хичээлийн агуулгыг хэрэглэх	Таамаглах
Чээжлэх	Хэмжих	Мэдээлэл унших	Өгөгдлийг шинжлэх, зүй тогтлыг таних	л дэвшүүлэх, шалгах
Давтах	Харьцуулах	Учир шалтгааныг тайлбарлах	Асуудлыг нээн илрүүлэх	Өгөгдөл болон таамаглах
Нэрлэх	Давтан гүйцэтгэх	Дүрслэн үзүүлэх	Шүүн тунгаах	лаас дүгнэлт гаргах
Хүүрнэх	Ангилгах	Сонголт хийх	Ашиглах	Зүй тогтол болон хэллэгийн үнэн зөвийг тодорхойлох
	Гүйцэтгэх	Цуглуулах	Боловсруулах	
	Биелүүлэх	Жишээ гаргах	Бүтээх	
	Өөрчлөх	Үнэлэх		
	Оруулах	Сонгон ашиглах		
	Бичих	Саналаа солилцох		
	Ажиллах	Шинжлэх		
	Зурах	Тодорхойлох		
	Суулгах	Илэрхийлэх		
	Ажиллуулах	Жишээ гаргах		
		Үйлдлүүдийг тодорхойлох		

¹Цэдэвсүрэн д., нар (2010) Мэдээлэл зүйн боловсролын стандартад портерийн загвараар шинжилгээ хийсэн судалгааны үр дүн, Лавай № 5, х: 86-90, Улаанбаатар

² А.С.Портер “Сургалтын агуулгыг хэмжих арга зүйг судалгааны ажилд хэрэглэх нь”, Орч: Д.Мөнхжаргал, 2009

Хүснэгт 1-т мэдээлэл зүйн боловсролын стандартад өргөн тохиолдож байгаа чадвар тодорхойлж байгаа үйл үгүүдийг харгалзах танин мэдэхүйн шалгуурт **тод налуугаар** тэмдэглэн оруулж өглөө.

Б. Ерөнхий боловсролын 12 жилийн мэдээлэл зүйн сургалтын хөтөлбөрийн талаар

Мэдээлэл зүйн үндэсний хөтөлбөрийг Мэдээлэл зүйн боловсролын стандартыг хэрэгжүүлэх багш нарт нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөрөө боловсруулах, хэрэгжүүлэх гарын авлага болон боловсруулсан³. Мэдээлэл зүйн боловсролын стандарт болон мэдээлэл зүйн хөтөлбөрийн агуулгын уялдаа холбоог Хүснэгт 2-т үзүүлээ.

ХҮСНЭГТ 2. МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН ХООРОНДЫН ХОЛБОО

Хөтөлбөрийн агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг (АТБХ)	Стандартын агуулгын ай
A1. МХХТ-ийн үндсэн ойлголтууд	1. Мэдээлэл 2. Алгоритм 3. Загвар, загварчлал
A2. Компьютер ашиглах ба файльтай ажиллах	4. Компьютер
A3. Текстэн мэдээлэл боловсруулалт	5. Мэдээллийн технологи 6. Загвар, загварчлал
A4. Хүснэгтэн мэдээлэл боловсруулах	
A5. Зурган мэдээлэл боловсруулалт	
A6. Үзүүлэн бэлтгэх ба дуун, хөдөлгөөнт дүрсэн мэдээлэл боловсруулах	
A7. Өргөн боломжит өгөгдлийн сан үүсгэх	
A8. Вэб хуудас, интернэт ашиглах	

Мэдээлэл зүйн боловсролын стандарт, хөтөлбөрөөр тодорхойлсон сурагчийг эзэмших мэдлэг, хэрэглээний чадварыг үндэслэн Мэдээлэл зүйн сурах бичгийг БСШУ-ны сайдын тушаалаар байгуулсан баг 2009 оноос эхлэн боловсруулж, 6-аас 12 дугаар ангийн сурах бичиг, 6-7, 11-12 ангийн багшийн номыг бичиж, өдгөө ЕБС-ийн сургалтад хэрэглэгдэж байна.

II. МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

Мэдээлэл зүйн суурь боловсролын хөтөлбөрийн мэдлэг, чадварын тодорхойлолтыг Хүснэгт 3-т, бүрэн дунд боловсролын чадварын тодорхойлолтыг Хүснэгт 4-т тус тус үзүүлээ.

ХҮСНЭГТ 3. МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ПОРТЕРИЙН ЗАГВАРААР СУДАЛСАН ҮР ДҮН (АНГИ, ТАНИН МЭДЭХҮЙН ТҮВШНЭЭР)

³ Д.Цэдэвсүрэн нар (2010) Мэдээлэл зүйн боловсролын стандартад портенийн загвараар шинжилгээ хийсэн судалгааны үр дүн, Лавай дугаар 5, х: 86-90, Улаанбаатар

АТБХ	Танин мэдэхүйн түвшин					Чадварын тоо
	СС ^a	ҮГ ^b	УО ^c	АШ ^d	ЕН ^e	
VI	20	23	1	1	0	45
VII	35	34	2	0	0	71
VIII	11	37	42	30	4	124
IX	1	12	37	1	1	52
Нийт	67	106	82	32	5	292

^a Сэргээн санах
^b Үйлдэл гүйцэтгэх
^c Ухаарч ойлгох
^d Асуудал шийдвэрлэх
^e Ерөнхийлөх, нотлох

Мэдээлэл зүйн суурь боловсролын хүлээгдэж буй үр дүн, мэдлэг, чадвар, хэрэглээний түвшинг тодорхойлолтыг нийтэд нь авч үзвэл нийт 292 тодорхойлолтоос 32 хувь нь сэргээн санах; 36 хувь нь үйлдэл гүйцэтгэх; 28 хувь нь ухаарч ойлгох; 11 хувь нь асуудал шийдвэрлэх түвшинд; ердөө 2 хувь нь ерөнхийлөх нотлох түвшинд тодорхойлогдсон нь суралцагчид суурь боловсролын түвшинд мэдээлэл зүйн хичээлээр ерөнхийлөх нотлох түвшний чадварт суралцах боломж хязгаарлагдмал байгааг харууллаа.

ХҮСНЭГТ 4. МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ПОРТЕРИЙН ЗАГВАРААР СУДАЛСАН ҮР ДҮН (АНГИ, ТАНИН МЭДЭХҮЙН ТҮВШНЭЭР)

АТБХ	Танин мэдэхүйн түвшин					Чадварын тоо
	СС	ҮГ	УО	АШ	ЕН	
X	0	74	57	21	0	152
XI	0	85	62	17	0	164
XII	2	39	19	12	0	72
Нийт	2	198	138	50	0	388

Бүрэн дунд боловсролын “Үзүүлэн бэлтгэх ба дуун, хөдөлгөөнт дүрсэн мэдээлэл боловсруулах” агуулгад ухаарч ойлгох түвшний чадварууд, “Өгөгдлийн сан үүсгэх” агуулгад үйлдэл гүйцэтгэх түвшний чадвар илүү олон, харин “МХХТ-ийн үндсэн ойлголтууд” агуулгад Асуудал шийдвэрлэх түвшний чадварууд харьцангуй их тусгагдсан. Мөн 10, 11 дүгээр ангид сэргээн санах түвшний чадвар огт тодорхойлогдоогүй байна.

Мэдээлэл зүйн суурь боловсролын А1-ээс А8 айн хүлээгдэж буй үр дүн, мэдлэг, чадвар, хэрэглээний түвшинг тодорхойлолтыг нийтэд нь авч үзвэл нийт 388 тодорхойлолтоос 1 хувь нь сэргээн санах; 51 хувь нь үйлдэл гүйцэтгэх; 36 хувь нь ухаарч ойлгох; 13 хувь нь асуудал шийдвэрлэх түвшинд; харин ерөнхийлөх нотлох түвшний чадвар огт тодорхойлогдоогүй байгаа нь суралцагчид бүрэн дунд боловсролын түвшинд мэдээлэл зүйн хичээлээр ерөнхийлөх нотлох түвшний чадварт суралцах боломжгүйг харуулж байна.

III. ДҮГНЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгааны үр дүнг дүгнэж үзвэл Мэдээлэл зүйн үндэсний хөтөлбөр нь **Үйлдэл гүйцэтгэх, ухаарч ойлгох** түвшинд төвлөрсөн, **агуулгын гүнзгийрэл гүехэн боловсруулагдсан** байна. Хөтөлбөрийн нийт 680 чадварын 303 нь буюу 45 хувь нь **үйлдэл гүйцэтгэх**, мөн 220 буюу 32 хувь нь **ухаарч ойлгох** түвшинд тодорхойлогдсон нь байгаа нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна. Хөтөлбөрийн агуулгын гүнзгийрэл гүехэн байгаа нь сурагчид онолын мэдлэг голлосон, дидактик материал нь мэдээлэл өгөхөөр боловсруулагдах, цаашилбал, сурах бичгийг мэдээлэл өгөхөөр боловсруулах үндэс болж, хичээлийн чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.



Зураг 1. Мэдээлэл зүйн үндэсний хөтөлбөрийн чадварын тодорхойлолтыг Портерийн загвараар судалсан үр дүн

Мэдээлэл зүйн боловсролын бодлого, хөтөлбөрийг шинэчлэхдээ Монгол улсын мэдээлэл зүйн боловсролын хүрсэн түвшин, туршлага, сургамж, Мэдээлэл зүй, МХХТ-ийн бичиг үсгийн боловсролын хүрээнд олон улсын бодлого, чиг баримжаа, МХХТ-ийн орчин үеийн хөгжлийн чиг хандлага, XXI зуун, тодорхойгүй нийгэмд амьдрах иргэний хөгжил, төлөвшил, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх нь зүйн хэрэг болж байна.

Ном зүй

[1] *Бага дунд боловсрол. Мэдээлэл зүйн боловсрол, MNS 5420-7:20048* (2005) Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Улаанбаатар

[2] *Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн VI-VII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж* (2012), Улаанбаатар

[3] Цэдэвсүрэн, Д. нар (2010) *Мэдээлэл зүйн боловсролын стандартад Портерийн загвараар шинжилгээ хийсэн судалгааны үр дүн*, Лавай дугаар 5, х: 86-90, Улаанбаатар

[4] Портер, А.С (2009) *Сургалтын агуулгыг хэмжих арга зүйг судалгааны ажилд хэрэглэх нь*, орч: Д.Мөнхжаргал

[5] Цэдэвсүрэн, Д (2014) *Мэдээлэл зүйн ба мэдээлэл зүйн боловсрол, МХХТ ба боловсрол эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл*, дугаар 6, х: 1-5, Улаанбаатар